

МОНГОЛ УЛСЫН  
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 11 сарын 22 өдөр

Дугаар 264

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2 дахь хэсэг, 52 дугаар зүйлийн 52.1.3 дахь заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Бүртгэл хөтлөх журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, Маягт 1 /Мэдүүлгийн маягт/-ийг хоёрдугаар хавсралтаар, Маягт 2 /Үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаарх мэдээлэл/-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газар /Э.Хангай/, Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төрийн сангийн газар /Ч.Тавинжил/, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Б.Батцэцэг/-т тус тус үүрэг болгосугай.


3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2013 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн 214 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



Ч.УЛААН

Сангийн сайдын 2013 оны 11  
дүгээр сарын 22-ны өдрийн 264  
дүгээр тушаалын нэгдүгээр  
хавсралт



## БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь тендерт оролцохыг сонирхогч хуулийн этгээд, иргэний бүртгэлийг холбогдох төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх)-аас хөтлөх, мэдээллийн сан бүрдүүлэх, тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлийг хөтлөх, тэдгээрийг мэдээллэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Яам нь худалдан авах ажиллагааны бүртгэл, мэдээллийн санг худалдан авах ажиллагааны удирдлага, хяналт шинжилгээний мэдээллийн систем /цаашид “систем” гэх/ (<http://pmmis.e-procurement.mn>)- ийг ашиглан энэхүү журам болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгон бүртгэж, мэдээллийн санг бүрдүүлнэ.

### Хоёр. Бүртгэл, мэдээллийн санд бүртгүүлэх хүсэлт гаргах

- 2.1 Хуулийн этгээд, иргэн (цаашид “хүсэлт гаргагч этгээд” гэх) нь бүртгүүлэх хүсэлтээ энэ журмын хавсралт 1-д заасан мэдүүлэг болон нотлох баримтын хамт холбогдох яаманд хүргүүлнэ.
- 2.2 Энэхүү журмын 2.1-д заасан хүсэлт гаргагч нь дараах мэдээллийг ирүүлнэ.
  - 2.2.1 Мэдүүлэг /Хавсралт 1/;
  - 2.2.2 Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар;
  - 2.2.3 Тусгай зөвшөөрлийн хуулбар;
  - 2.2.4 Шаардлагатай тохиолдолд төлөөлөх эрх бүхий этгээдийн итгэмжлэл;
  - 2.2.5 Үйл ажиллагааны чиглэл, чадвар, туршлагын талаарх мэдээлэл /Хавсралт 2/;
  - 2.2.6 Албан ёсны хаяг /утас, факс, цахим шуудан гэх мэт/.
- 2.3 Энэхүү журмын 2.2-т заасан мэдээллийн үнэн зөвийг хүсэлт гаргагч этгээд бүрэн хариуцна.
- 2.4 Хүсэлт гаргагч этгээд нь энэ журмын 2.2.5-д заасан мэдээллийг ирүүлэхдээ дараах зүйлсийг хавсралт 2-т заасны дагуу тусгаж ирүүлнэ.

